



**АРХАНГАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ
НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ТАНИЛЦУУЛГА**

12/2016

ЦЭЦЭРЛЭГ ХОТ



ӨРХ ХҮН АМ

2016 оны эцэст манай аймаг 27,1 мянган өрх, 93,5 мянган хүн амтай байна. Өрх хүн амыг байршлаар нь авч үзвэл нийт өрхийн 20,6 хувь нь буюу 5,6 мянган өрх, хүн амын 19,1 хувь буюу 17,9 мянган хүн сумын төвд, 21,4 хувь буюу 5,8 мянган өрхийн 21,5 мянган хүн аймгийн төвд оршин сууж байна.

Нийт өрхийн дотор 6 ба түүнээс дээш гишүүнтэй өрх 1,4 мянга, 18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 2,0 мянга байна. 1584 ганц бие өндөр настан өрх байгаагийн 68,6 хувь нь 55 ба түүнээс дээш насны эмэгтэй байна. Аймгийн дүнгээр өрхийн дундаж ам бүл 3,4, хүн амын нягтрал 1 км²-д 1,7 байна.

Нийт хүн амын 49.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж хүйсийн харьцаа 100,3 байна. Насны хувьд нийт хүн амын 33.4 хувийг 0-16 насны хүүхдүүд, 30,4 хувийг 18-35 насны залуучууд, 6,7 хувийг 60-аас дээш насны хүн ам эзэлж байна. Аймгийн хэмжээгээр 90-99 настай 78 хүн, 100-аас дээш настай 3 хүн байна.

Аймгийн хэмжээнд 1851 өнчин хүүхэд байгаагийн 6,5 хувь нь бүтэн өнчин хүүхдүүд байгаа ба нийт өнчин хүүхдийн 26,4 хувийг 0-9 насны хүүхдүүд эзэлж байна.

Өрх толгойлсон 2780 эмэгтэйчүүд байгаагийн 4,1 хувь нь 6 ба түүнээс дээш ам бүлийг тэжээж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 3513 хүн байгаагаас 1573 нь эмэгтэй, 1443 нь төрөлхийн тахир дутуу хүмүүс байна.



СОЁЛ УРЛАГ, БОЛОВСРОЛ

Хөгжимт драмын театр 2016 онд 4 уран бүтээл шинээр хийж 55 удаа тоглолт зохион байгуулан давхардсан тоогоор 35,4 мянган хүнд үйлчилж урын сандаа 32 бүтээлтэй

байна.Өнгөрсөн оныхоос тоглолт, үзэгчдийн тоо 20,3-22,9 хувиар буурсан байна.

Аймгийн музейн хамт олон 3,9 мянган үзмэрээр 6,1 мянган хүнд үйлчилж 7,6 сая төгрөгийн орлоготой ажилласан байна,

Төв хөдөөгийн болон сургуулиудын 50 номын сан 74.5 мянган хүнд давхардсан тоогоор 322.9 мянган номоор үйлчилж оны эцэст 649,9 мянган ширхэг номын фондтой байна,

Сумдын соёлын төвүүд 2500 удаа урлаг, уран сайхны ажил зохиож түүнд давхардсан тоогоор 217.0 мянган хүн хамрагдаж 35,0 сая төгрөгийн орлоготой ажиллав.

2016-2017 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 33 сургуулийн 672 бүлэгт 17,3 мянган хүүхэд суралцаж, 36 цэцэрлэгт 7,1 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд 1-р ангид 1.8 мянган хүүхэд, 10-р ангид 0.5 мянган хүүхэд элссэний гадна 2.2 мянган хүүхэд ЕБСургуулийн дотуур байранд сууж байна.

Манай аймагт эдийн засгийн чиглэлийн 1 дээд сургууль ажиллаж түүнд 110 оюутан, Багшийн коллежид 624 оюутан суралцаж байна. Аймгийн төвийн төрийн болон хувийн хэвшлийн дөрвөн МСҮТөвд талх нарийн боовчин, тогооч, үсчин гоо сайханч, фермерч, компьютер албан хэрэг хөтлөгч, оёдол эсгүүрчин, автомашины болон цахилгаан хэрэгслийн засварчин, сантехникч гагнуурчин, барилгын өрлөг болон засал чимэглэгч зэрэг 10 гаруй төрлийн мэргэжлээр 1101 хүүхэд суралцаж байна.




ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 519 ор, амбулаторийн 101 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 289,7 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 114,6 мянгад нь урьдчилан

сэргийлэх үзлэг хийж 20,9 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98,8 хувийг бүрэн хамруулсны дотор Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан сумд 100,0 хувь хамруулсан байна.


Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



Тайлант онд 1951 эхээс 1957 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оныхоос 4,6 хувиар буюу 94 хүүхдээр бага байна,

Хүн амын нас баралт 488 гарсан нь өнгөрсөн оныхоос 8 тохиолдлоор буюу 1,6 хувиар бага байна. Мянган хүнд ноогдох төрөлт 20,9, нас баралт 5,2 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 15,7 промил байна. Нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 17 гарч мянган амьд төрөлтөд 8,7 ноогдож өнгөрсөн оныхоос 9 тохиолдлоор ихэссэн байна.

Эндсэн хүүхдийн тоо



Нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 37 гарч мянган амьд төрөлтөд 18,9 ногдож байгаа нь өнгөрсөн оныхоос 8 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 150 нь буюу 1470 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Эрдэнэбулган(300), Жаргалант (364), Өгийнуур (233), Ихтамир(162) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 0,7 хувь нь гепатит, 3,4 хувь нь салхин цэцгээр, 67,4 хувь нь улаан бурханаар, 16,9 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 4,7 хувь нь сүрьеэгээр, 6,9 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Өнгөрсөн оныхоос халдварт өвчний гаралт 2,5 дахин буюу 896 тохиолдлоор нэмэгдсэн байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР


12 дугаар сарын 31-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 2042 ажилгүй хүн байгаагийн 47,4 хувь нь буюу 968 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10,0 мянган хүн тутамд 197 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оныхоос бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 77,3 хувиар нэмэгдсэн байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 97,4 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 350 нь дээд, 108 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 1328 нь бүрэн болон бүрэн бус дунд, 204 нь бага боловсролтой хүмүүс байна.

12 дугаар сард ажилгүйчүүдийн бүртгэлд 369 хүн шинээр бүртгүүлж, 43 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болж, 255 хүн ажилд зуучлуулан орсон байна.

Энэ онд аймгийн дүнгээр 774 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар авч үзвэл

Эрдэнэбулгансум 296, Жаргалант, Ихтамир, Хотонт, Тариат, Төвшрүүлэх, Өгийнуур сумд 33-83 ажлын байрыг, Хангай, Батцэнгэл, Хайрхан, Эрдэнэмандал сумд 22-29 ажлын байрыг, Чулуут, Булган, Цэцэрлэг, Цахир сумд 11-18 ажлын байрыг, Цэнхэр, Хашаат, Өлзийт сумд 7-9 ажлын байрыг тус тус бий болгосон байна.

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэний тоо



НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 онд 49,9 тэрбум төг, зарлага 50,2 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 9904,5 сая төг буюу 24,7 хувь, зарлага 9279,6 сая төг буюу 22,6 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 9904,5 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 26,2 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 29,5 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 5,5 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 1,0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 22,6 хувиар өсөхөд тэтгэврийн, эрүүл мэндийн, ажилгүйдлийн даатгалын сангууд өссөн нь голлон нөлөөлөв. Тэтгэврийн

даатгалын сангаас тэтгэвэрт 37,1 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 1,6 тэрбум төгрөгийг олгосон байна.

Энэ онд нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 29,1 мянган хүнд 10241,0 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 62,2 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт 37,8 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 52,3 хувийг халамжийн тэтгэврээр, 26,4 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 21,3 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.


Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц



ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 549 холбогдогч бүхий 536 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 174, өмчлөх эрхийн эсрэг 277, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 59, байгаль хамгаалах журмын эсрэг 5, бусад 21 хэрэг гарсан байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо



Гэмт хэргийн улмаас 20 хүн нас барж, 209 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 2389,3 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 10,4 хувийг бүлэглэж 27,8 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 770 хүнийг албадан саатуулж 34 хүнийг баривчилсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 4,7 хувиар буюу 24 тохиолдлоор нэмэгдсэний дотор хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 27,0 хувиар буюу 33 тохиолдлоор өсч харин өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 0,4 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2016 онд аймгийн төсөвт 20636.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 22085.5 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 107,0 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 7410,8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 8859,8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 119,6 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг Цэцэрлэг, Хайрхан, Батцэнгэл, Өлзийт, Өгийнуураас бусад бүх сумд 101,3 -384,7 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Орлогыг нэр төрлөөр нь үзвэл бууны албан татвар, агнуурын нөөц ашигласны төлбөр, ойгоос мод түлээ ашигласны төлбөр, түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөрөөс бусад нэрийн орлогуудыг 100,1 – 274,8 хувиар биелүүлсэн байна.


Аймгийн төсвийн орлогын 59,9 хувийг тусламжийн орлогоор, 20,0 хувийг орлогын албан татвараар, 1,3 хувийг өмчийн татвараар, 1,1 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 13,7 хувийг бусад албан татвараар, 3,3

хувийг татварын бус орлогоор, 0,7 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 240,1 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 921,2 сая төгрөг, ашигт малтмалыг эзэмшдэг ашигласны төлбөрөөр 354,7, онцгой албан татвараар 17,5 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 22,5 сая төгрөг бүгд 1556,0 сая төгрөгийг шилжүүлээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 62766,1 сая төгрөг байгаагийн 46,9 хувийг цалин хөлсөнд, 5,3 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 47,8 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 40,6 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээнд, 49,3 хувийг боловсролын салбарт, 9,4 хувийг эрүүл мэндийн салбарт, 0,4 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0,3 хувийг бусад салбарт зарцууллаа.

Орон нутгийн төсвийн байгууллагын нийт зарлагын бүтэц, хувиар



МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас

зузаатгалаар 23,4 тэрбум төгрөгийг авч 27,9 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

2016 онд банкууд 60,9 мянган иргэд, аж ахуй нэгжид 113,2 тэрбум төгрөгийн зээл олгосны дотор 169 хүнд 7409,5 сая төгрөгийн орон сууцны зээл олгосон байна.



Өнгөрсөн онтой зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 24,4 хувиар, олгосон зээлийн хэмжээ 9,1 хувиар өсч харин чанаргүй зээлийн хэмжээ 2,0 дахин, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 12 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2016 оны 12 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0,1 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 6,1 хувиар, 2010 оны 12-р сарынхаас 93,7 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 11 дүгээр сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 214 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 8,4 хувийнх нь өсч, 2,8 хувийнх нь үнэ буурч, 88,8 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас бүх төрлийн малын махны үнэ 3,1- 10 хувиар буурч харин тараг, мүү, гурилан боов, алим, өөхөн тос, байхуу цай, алаг салат, жимсний шүүс, эрэгтэй хүүхдийн сорочкон цамц, ноосон цамц, трико, модон орны үнэ 2,2 – 33,3 хувиар нэмэгдсэн байна.

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 47,7 хувийнх нь буюу 102 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 5,6 хувийнх нь буюу 12 нэрийн барааны үнэ буурч, 46,7 хувийнх нь үнэ тогтвортой байна.

Өнгөрсөн оны мөн үеийнхээс төмс, байцаа, лууван, манжин, бүх төрлийн шатахуун, өөхөн тос, дотор мах, тарагны үнэ 6,7 – 38,5 хувиар буурч, харин хатуу чихэр, цай, давс, тамхи, ундаа, шар,цагаан будаа, алим, элсэн чихэр, сурагчийн цүнх, сурагчийн дөрвөлжин шугамтай дэвтэр, лаа,трико 4-5 настай охидын, хүүхдийн пүүз,эрэгтэй эмэгтэй хүний гадуур, дотуур хувцас, гутал, ботинк, даавуу, гэр ахуйн хэрэгсэл, тавилга, оо, саван,тамхи, түлшний мод, парацетамол эм болон даралтны эм зэрэг барааны үнэ 1,3- 76,9 хувиар нэмэгдсэн байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ


Аймгийн дүнгээр 2016 оны эцэст 5009,6 мянган мал тоологдсоны дотор 0,02 хувь буюу 1,2 мянга нь тэмээ, 7,1 хувь буюу 356,8 мянга нь адуу, 11,6 хувь буюу 581,2 мянга нь үхэр, 53,3 хувь нь буюу 2668,0 мянга нь хонь, 28.0 хувь буюу 1402,4 мянга нь ямаа байна.



Өнгөрсөн оныхоос нийт малын тоо 12,4 хувиар буюу 552,6 мянган толгойгоор өссөний дотор тэмээ 15,6 хувиар буюу 168 толгойгоор, адуу 10,1 хувиар буюу 32,7 мянган толгойгоор, үхэр 6,8 хувиар буюу 37,0 мянган толгойгоор, хонь 15,1 хувиар буюу 351,0 мянган толгойгоор, ямаа 10,4 хувиар буюу 131,7 мянган толгойгоор тус тус төрөл бүр дээрээ өссөн байна.

Сумдаас Эрдэнэмандал 473,6 мянган малтай, Батцэнгэл(372,5мянга), Ихтамир (338,7), Өндөрүлаан (328,2), Хашаат (328,1), Хайрхан(327,0) , Цэцэрлэг(319,0), Хотонт(316,0), гэсэн 7 сумд 300-аас дээш мянган малтай, Цэнхэр(297,5), Өгийнуур (291,5), Өлзийт (282,6), Жаргалант (273,7), Тариат (239,2), гэсэн 5 сумд 200-аас 298,0 мянган малтай, Эрдэнэбулган(195,5мянга), Чулуут(187,5), Төвшрүүлэх(135,3), Булган (112,9) гэсэн 4 сум 100-аас 196,0 мянган толгой малтай байна. Сумд дотроос адуугаар Эрдэнэмандал(27,9 мянга), Хотонт(28,0), Цэнхэр(27,6), сумд, үхрээр Ихтамир(55,0 мянга), Өндөрүлаан (54,0), Чулуут(48,1) сумд, хониор Эрдэнэмандал(316,8 мянга), Батцэнгэл(206,8), Хашаат(188,1) сумд, ямаагаар Хотонт(117,4 мянга), Хашаат (101,9), Батцэнгэл(101,8) сумд, тэмээгээр Хашаат(421 толгой), Өгийнуур(349 толгой), Өлзийт (346 толгой), сумд тус тус тэргүүлж байна.

Төл бөйжилтын хувь



Энэ онд оны эхний хээлтэгч малын 86,1 хувь нь буюу 1641,0 мянган эх мал төллөж гарсан төлийн 97,0 хувь нь буюу 1592,5 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботго 96,6 хувиар, унаганы 96,2 хувь, тугалын 96,8 хувь, хурганы 97,7 хувь, ишигний 96,0 хувь нь бойжиж байна. Сумдаас Төвшрүүлэх, Эрдэнэмандал, Өгийнуур сумд гарсан төлөө 99,0-өөс дээш хувиар бойжууллаа.

2016 оны эцэст 174 гахай, 61 шувуу, 70 бүл зөгийг иргэд тэжээж бүтээгдэхүүнийг нь авч ашиглаж байна.


2016 оны эцсийн байдлаар малаа жилийн дөрвөн улиралд маллаж мал аж ахуйгаасаа өрхийн орлогын дийлэнхи хэсгийг олж амьдардаг 14436 малчин өрх байна. Малчин өрхийн 89,2 хувь нь буюу 12,9 мянга нь цахилгаан гэрэлтэй, 74,5 хувь нь буюу 10,8 мянга нь телевизортой, 12,2 хувь нь радиотой, 75,2 хувь нь буюу 10,9 мянга нь гар утастай, 49,4 хувь нь буюу 7,1 мянга нь оёдлын машинтай байна.

Аймгийн дүнгээр нийт малчин өрхийн 2,2 хувь нь буюу 324 өрх 10 хүртэл малтай, 4,8 хувь нь буюу 692 өрх 11-30 хүртэл, 4,8 хувь нь буюу 691 өрх 31-50 хүртэл, 11,3 хувь нь 1628 өрх 51-100 хүртэл, 23,2 хувь нь буюу 3348 өрх 101-200 хүртэл, 35,1 хувь нь буюу 5063 өрх 201-500 хүртэл, 13,3 хувь нь буюу 1925 өрх 501-999 хүртэл, 5,3 хувь нь буюу 765 өрх 1000-аас дээш малтай байна. 2015 оныхтой зэрэгцүүлэхэд нийт малчин өрхийн 23,1 хувь нь 100 хүртэл малтай байгаа нь 1,1 пунктээр буурч харин 201-500 малтай өрхийн эзлэх хувь 0,3 пунктээр, 501-ээс дээш малтай өрхийн эзлэх хувь 3,3 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээгээр 1000-аас дээш толгой малтай 765 өрх байгаагийн 43 нь 2001-ээс дээш малтай, 86 нь 1500-2000 малтай, 636 нь 1000-1499 малтай байна.

Энэ онд улс орон нутгийн төсвийн болон төсөл хөтөлбөрийн 259.4 сая төгрөгөөр 31 худаг шинээр гаргаж 27.9 сая төгрөгөөр 16 худгийг засварласан байна.

2016 онд оны эхний мал 96,7 хувиар онд орж оны эхний малын 3,3 хувь буюу 147,4 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 5,6 хувийг адуу, 28,9 хувийг үхэр, 42,1 хувийг хонь, 23,4 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр




Сумдаас Хотонт,Төвшрүүлэх, Цэнхэр, Батцэнгэл, Эрдэнэмандал сумд оны эхний малаа 99,0-99,9 хувиар онд оруулан хамгийн бага хорогдолтой байна. Харин Хангай сумын оны эхний малын 23,2 хувь буюу 24,6 мянган мал, Цахир суманд оны эхний малын 18,7 хувь буюу 18,7 мянган мал, Өндөрүлаан суманд оны эхний малын 6,2 хувь буюу 18,7 мянган мал хорогдсон нь хамгийн их хорогдолтой байна.

Аймгийн хэмжээгээр энэ онд 5076,0 га-д үр тариа, 459,7 га-д төмс, 155,2 га-д хүнсний ногоо, 1440,4 га-д малын тэжээлийн ургамал, 790 га-д техникийн ургамал тус тус тариаллаа. Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд тариалсан үр тариа 20,5 хувиар буюу 865 га-аар, тэжээлийн ургамал 1,6 хувиар, Хүнсний ногоо 1,2 хувиар илүү, харин техникийн ургамал 38,3 хувиар, төмс 2,4 хувиар тус тус бага байна.

2016 онд аймгийн хэмжээгээр 7310 тонн үр тариа, 3531,6 тонн төмс, 1191,1 тн хүнсний ногоо, 4661,0 тн ногоон

тэжээл , 563,0 тн техникийн ургамал хураан авлаа. өнгөрсөн оны мөн үеийнхээс хураан авсан үр тариа 2,7 дахин их, тэжээлийн ургамал 2,8 хувиар, техникийн ургамал 69,1 хувиар илүү, харин төмс 0,2 хувиар, хүнсний ногоо 7,7 хувиар бага байна. Мөн 84,6 мян.тн байгалийн хадлан, 1292,3 тн гар тэжээл бэлтгэсний дотор сумын аюулгүйн нөөцөнд 1033 тн өвс, 372 тн тэжээл нөөцөлсөн байна.

Хураасан үр тариа, төмс, хүнсний ногоо тн-оор,



2016 онд манай аймаг ойгоос 102,6 мянган м3 галын түлээ, 12,6 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 115,2 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас 97,1 мянган м3 галын түлээ, 7,8 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 104,9 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 304,0 сая төгрөг төсвийн орлогод оруулж, ойн зөрчил торгуульд 9,7 сая төгрөгийн торгууль, нөхөн төлбөр оногдуулсан байна.




АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2016 онд оны үнээр 6366,8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан нь өнгөрсөн

оныхоос 16,7 хувиар илүү байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 2357,2 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 17,8 хувиар илүү байна.

Нийт үйлдвэрлэлтийн 8,2 хувийг хүнс ундааны, 1,4 хувийг хэвлэлийн, 65,0 хувийг дулааны эрчим хүчний, 13,2 хувийг усан хангамж, 4,5 хувийг модон эдлэлийн, 4,1 хувийг гутал хувцасны, 3,6 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, эсгий, түгээсэн цэвэр ус, дулаан, монгол болон савхин гутал, тонгол дээл, хүрмэн блок, гэрийн мод, модон тавилгын үйлдвэрлэлт 3,1 хувиас 2,5 дахин нэмэгдлээ. Харин савласан цэвэр ус, бууз, архи, хэрчсэн гурил, зүсмэл, хүснэгт маягт, вакуум цонхны үйлдвэрлэлийн хэмжээ 3,4 – 70,0 хувиар буурсан байна.



БАРИЛГА

Барилгын байгууллагууд 10196,2 сая төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 6,7 дахин буурсан байна. Нийт ажлын 89,5 хувь нь угсралтын ажил 10,5 хувь нь их засварын ажил байна.



ТЭЭВЭР

Тээврийн байгууллагууд 46,6 мянган зорчигч, 18,5 мянган тонн ачаа тээвэрлэн 21,6 сая хүн км, 7,1 сая ткм ажил гүйцэтгэн 632,4 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлтийн хэмжээ 17,0-17,8 хувиар нэмэгдэж харин ачаа эргэлт, тээсэн ачаа, орлогын хэмжээ 4,1-35,9 хувиар багассан байна.

Холбооны байгууллагууд 500 телефон цэг, улс хот хоорондын телефоны яриа, интернет, телевизийн болон шуудангийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 317,4 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оныхоос 6,0 хувиар буурсан байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

12 дугаар сард агаарын дундаж температур -10,2-оос -22,2 хэм хүйтэн байсан бөгөөд хамгийн их дулаан Төвшрүүлэх, Эрдэнэбулган, Хотонт, Цэцэрлэг сумдад 1,0 - 7,0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Хангай, Өлзийт, Өгийнуур, Цахир сумдад -31,0-ээс -34,0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Энэ сард Эрдэнэбулган, Чулуут, Тариат, Хашаат, Хотонт, Төвшрүүлэх сумдын нутгаар 4,4-8,4 мм цас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Батцэнгэл, Жаргалант, Хангай сумдад 0,4 – 1,0 мм тундас орсон нь хамгийн бага байна.

Статистикийн хэлтэс
2017.01.09